

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255006>

АЛБАН БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ, ЗАР СУРТАЛЧИЛГААГ
ХЭРЭГЛЭЭНИЙ ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ҮҮДНЭЭС СУДЛАХ НЬ
(ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЖИШЭЭГЭЭР)

Т.Марал
Л.Нарантуяа
Б.Өлзийтэгш

Түлхүүр үг: хаягжилт, байгууллагын хаяг, хаягжилтын стандарт, зөв бичгийн дүрмийн алдаа, найруулгын алдаа

1. Удиртгал

Албан байгууллагын хаяг, зар сурталчилгааг оновчтой болгох, сайжруулах чиглэлээр хийгдсэн судалгааны бүтээлүүд цөөнгүй байдаг бөгөөд эдгээрээс судлаач Н.Гансэлэм “Хаяг рекламны тухай журам” нийтлэл, 2012, О.Ган-Эрдэнэ “Хаяг, рекламны найруулга зүй” 2015, Т.Нармандах “Зар сурталчилгааны хэл найруулгын судалгаа” 2020, SHUUD.MN сайт “Үйлчилгээний байгууллагууд алдаатай хаяг хадсаар л байх уу” нийтлэл, 2023, Г.Гэрэлмаа “Хэлний хэрэглээг эргэцүүлэхүй” 2023, Б. Мөнхжаргал “Аж ахуйн нэгжийн оноосон нэрийн зарим асуудалд” магистрын ажил, Дархан., 2020, Л. Нарантуяа “Дархан-Уул аймгийн компани, Аж Ахуйн Нэгжийн оноосон нэрд хийсэн хэлзүйн судалгаа” Дархан., 2020, Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс гаргасан “Хаягийн судалгаа” I,II 2017 зэргийг дурдаж болно. Эдгээр судалгааны ажил, нийтлэлүүдэд хаяг, зар сурталчилгаанд гарч буй алдаанууд нь хэрэглэгчийн мэдээлэл хүлээн авах ойлголтыг гажуудуулж, буруу ташаа ойлголт төрүүлэх, улмаар хэрэглэгчийн итгэлийг алдах, байгууллагын талаарх сөрөг хандлагыг бий болгох эрсдэлтэй. Мөн монгол хэлний дархлааг сулруулж, хэлний соёлын доройтолд хүргэх сөрөг үр дагавартай болохыг судлаачид сануулсан байна. Ийм учраас байгууллагууд зөв бичгийн дүрмийн алдаагүй, найруулгын хувьд ойлгомжтой, стандартын шаардлага хангасан хаяг, зар сурталчилгаа ашиглах нь хэлний соёл, харилцааны чанарыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй. Тиймээс энэ чиглэлийн судалгаанууд нь зөвхөн хэл шинжлэл, харилцаа холбооны хүрээнд төдийгүй байгууллагын дотоод соёл, хэрэглэгчийн хандлага, нийгмийн хэлний бодлогод хүртэл тодорхой нөлөө үзүүлж чадах ач холбогдолтой юм.

1.1. Судалгааны ажлын зорилго: Дархан-Уул аймаг дахь ААН, байгууллагуудын хаягжилтын хэл найруулга, стандартын хэрэгжилтийг судлахад оршино.

1.2. Судалгааны ажлын зорилт:

- Дархан-Уул аймаг дахь ААН, байгууллагуудын хаягжилтын зөв бичгийн болон найруулгын алдааг илрүүлэх

- Хаягжилтад баримтлах стандартын хэрэгжилтийг судлах
- Судалгаанд тулгуурлан нийтлэг, алдаа зөрчлийг ангилан ялгах
- Жишиг хаягуудын судалгааг гаргах
- Хаягжилтын чанарыг сайжруулах, стандартын хэрэгжилтийг хангах талаар

Дархан-Уул аймаг дахь “Хэлний бодлогын үндэсний зөвлөл”-д саналаа хүргүүлэх

1.3. Судалгааны ажлын арга зүй: Энэхүү судалгааны ажлыг хийхдээ чанарын судалгааны арга зүйг баримтлан, хэрэглээний хэл шинжлэлийн үүднээс байгууллагын хаяг, зар сурталчилгааны хэл найруулга, зөв бичгийн алдаа болон стандартын хэрэгжилтийг судлан шинжилсэн.

1. Ажиглалт: Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн нийт 65 байгууллагын хаяг, зар сурталчилгааг газар дээр нь судлан баримтжуулсан. Хаягуудыг сонгохдоо төр, хувийн хэвшлийн тэнцвэрийг хадгалан, нийтлэг хэрэглээтэй, хэрэглэгчдийн анхааралд өртөх магадлал өндөр объектуудыг сонгон авсан.

2. Баримт цуглуулалт: Хаяг, зар сурталчилгааг гэрэл зургаар баримтжуулж, тэдгээрийг зөв бичгийн дүрэм, найруулга зүй, MNS 5283:2022 хаягжуулалтын стандартын хүрээнд дүгнэн ангилан ялгалт хийсэн.

3. Харьцуулалт: Төрийн байгууллагуудын хаяг стандартын шаардлагыг бүрэн хангасан байхад, хувийн хэвшлийн байгууллагуудын ихэнх нь стандарт зөрчсөн, эмх замбараагүй бичиглэлтэй байсныг илрүүлэн харьцуулав. Энэ нь байгууллагын төрөл ба хандлагын ялгааг харуулж байсан нь ажиглагдсан.

4. SWOT шинжилгээ: Судалгааны үр дүнд илэрсэн давуу болон сул тал, боломж, аюул занал зэргийг SWOT шинжилгээний аргаар дүгнэж, нийгэм хэл шинжлэлийн талаас нь үнэлэлт өгсөн болно.

1.4. Судалгааны ажлын хамрах хүрээ: Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулдаг ААН, байгууллагууд

1.5. Судалгааны ажлын шинэлэг тал: Энэхүү судалгааны ажлын шинэлэг тал нь хэрэглээний хэл шинжлэлийн үүднээс албан байгууллагын хаяг, зар сурталчилгааг хэл найруулга, зөв бичгийн дүрэм болон хаягжуулалтын стандартын хэрэгжилтийн бодит баримтад тулгуурлан үнэлж дүгнэсэн явдал юм. Судалгаа нь байгууллагуудын хаяг, рекламн хэлний хэрэглээнд гарч буй зөрчил, гадаад үг хэллэгийн хэт хэрэглээний шалтгаан, үр дагаврыг олон нийтийн хэл соёлын хүрээнд авч үзсэнээрээ шинэлэг бөгөөд цаг үеийн хувьд хэрэгцээтэй сэдэв болж байна гэж үзэж байна.

1.6. Судалгааны ажлын практикач холбогдол: Энэхүү судалгааны практикийн ач холбогдол нь байгууллагуудын хаяг, зар сурталчилгаанд хэл найруулга, зөв бичгийн дүрэм болон стандартын хэрэгжилтийг анхаарах шаардлагыг онцлон тодруулж, тэдгээрийг сайжруулахад чиглэсэн зөвлөмж, арга замыг тодорхойлоход оршиж байна. Мөн хэлний зөв хэрэглээг хэвшүүлэх, олон нийтийн хэлний соёлыг төлөвшүүлэх, хяналт шалгалт, сургалт сурталчилгаанд ашиглах бодит эх сурвалж, мэдлэгийн сан бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

2. Онолын хэсэг

Нэр зүй:

Аж ахуйн нэгж, албан газар байгууллагад оноон өгсөн нэрийн цогц нь хэл шинжлэлийн үгийн сан судлал хэмээх салбар ухааны **нэр зүй (ономастика)** гэдэг бүрэлдэхүүн хэсэгт багтдаг.

Нэр зүй нь аж ахуйн нэгж, албан газар, байгууллагын нэрээс гадна хүн, хүний эшийн нэр, амьтан, ургамал, газар ус, од, эрхэс, ном судар, бараа бүтээгдэхүүн зэргийн нэрийг судлан шинжилдэг ухаан.

Хэл судлаачдын үзэж байгаагаар “оноосон нэр бол нэг төрлийн олон юмнаас аль нэгийг онцлон ялгахын тул тусгайлан өгсөн нэр учраас утгын багтаамж нь ерөнхий нэрийнхээс явцуу бөгөөд нэгж утга, нэгж ухагдахуун илэрхийлдэг” (Өнөрбаян, 1998:129) онцлогтой.

Оноосон нэр нь нэр зүйн бусад нэгжийн адил товч, оновчтой, монгол хүний бэлгэдэх сэтгэлгээнд нийцсэн, хэлэх сонсоход эвтэй, бичиж уншихад хялбар, аль болох уугуул монгол үгээр байвал үндэснийхээ өвөрмөц онцлогийг хадгалж, эх хэлнийхээ цэвэр ариун байдлыг хангаж чадна. Ийм учраас төр засаг нэгжийн нэрийг данс бүртгэлдээ авч, хараа хяналтдаа байлгадаг. (Г.Гэрэлмаа, 2023)

Зөв бичих дүрэмд:

✓ Авиа зүйн холбогдолтой зөв бичих дүрэм (Эгшиг зохицох ёс, Балархай эгшгийн үүрэг

Онцгой гийгүүлэгч Б,В-ийн дүрэм, “Н,Г”-ийн дүрэм, Хатуу, зөөлний тэмдгийн дүрэм)

✓ Бүтээвэр зүйн холбогдолтой зөв бичих дүрэм (Үйл үг үүсгэх “Л” дагавар, Нөхцөлдүүлэн холбохын ж,ч нөхцөлийг хэрэглэх, Зарим тийн ялгалын нөхцөлийг зөв бичих)

Өгүүлбэр зүйн холбогдолтой зөв бичих дүрэм (Том үсгийн дүрэм, Үгийг хурааж бичих, Зарим чимэх үгийг зөв бичих, Цэгийг хэрэглэх тухай, Таслалыг хэрэглэх тухай, Асуултын тэмдгийг хэрэглэх тухай, Анхаарлын тэмдгийг хэрэглэх тухай, Давхар цэгийг хэрэглэх тухай, Хаалт, хашилт хэрэглэх тухай) зэрэг нь багтана. (МУБИС, 2022)

Найруулга зүйд:

✓ Найруулгын алдаа: (Үг буруу сонгосон, Үг илүүдсэн, Үг дутсан, Яруу хэрэглүүр оновчгүй, Үг давтсан)

✓ Найруулгын бус алдаа: (Баримтын алдаа, Учир зүйн алдаа, Хэл зүйн алдаа) зэрэг нь хамаарна.

Монгол хэлний тухай хуулиас:

... 5 дугаар бүлэг 17 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга

17.1.Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ:

17.1.1.харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд энэ хуулийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбоотой үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

17.1.2.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийг кирил болон үндэсний бичгээр хослуулан, эсхүл дангаар нь бичиж хэвших ажлыг зохион байгуулах;

17.1.3. үндэсний бичгийн хэрэглээг түгээн дэлгэрүүлэхэд идэвх санаачилга гарган ажиллаж байгаа иргэн, хуулийн этгээдийг урамшуулах ажлыг зохион байгуулах;

17.1.4. хуульд заасан бусад үүрэг.

Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага (MNS 5283:2022)

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн С/41 дүгээр тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

5.2 Хаягийн тэмдэгт тавих шаардлага

5.2.1 Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө хаягийн тэмдэгтэй байна.

5.2.2 Гудамж, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдгийн загвар, хэлбэр хэмжээ, өнгийг А хавсралтын А.1, А.2-р хүснэгтэд заасны дагуу мөрдөнө. Өнгөний код: Цагаан өнгө “RGB-255,255,255, Хөх өнгө RGB-0,79,158, хар өнгө “RGB-0,0,0”, ногоон өнгө “RGB-31; 138; 61”.

5.2.3 Гудамж, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн батлагдсан монгол нэрийг хаягийн тэмдэг дээр бичнэ. Орчуулж бичихийг хориглоно.

5.2.4 Гудамж, талбайн нэрийг түүхэн хүний нэрээр нэрлэсэн тохиолдолд нэрийг нь товчлон бичихгүй, овгийг товчилж болох бөгөөд нэрд орсон үг бүрийг том үсгээр эхлүүлэн бичнэ. Нэрд мэргэжил, мэргэжлийн зэрэг, цолыг оруулж болно. А хавсралтын А.1-р хүснэгт 2-р зурагт заасан байдлаар хийнэ.

5.2.5 Гудамжны нэрийн тэмдэг нь бие даасан шонд суурилуулах бөгөөд 2-оос дээш нэрийн тэмдэг байршуулах бол зориулалтын холбоосыг ашиглана.

5.3 Аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн самбарт тавих шаардлага

5.3.1 Аж ахуйн нэгж, байгууллага үйлчилгээгээ иргэдэд ойлгомжтой, чирэгдэлгүй, шуурхай байдлаар тав тухтай орчинд үзүүлэх нөхцөл боломжийг анхаарч үйл ажиллагаа явуулж байгаа барилга болон ажлын байрны гадна талд байгууллагын нэрийн тэмдгийг В хавсралтын В.6-р зурагт заасны дагуу байршуулна.

5.3.2 Төрийн байгууллагын нэрийн самбар нь нэрийн бичвэр, соёмбо, байгууллагын лого, бэлгэ тэмдэг зэргийг агуулна. байгууллагын бүтэн нэрийн бичвэр нь Монгол хэл, англи хэл, монгол бичгээр бичигдэнэ.

5.3.3 Төрийн байгууллагуудыг дараах байдлаар ангилна.

а). Төрийн гүйцэтгэх дээд байгууллага, Яам түүний харьяа агентлаг, газар;

б). Аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд;

с). Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа байгууллага.

5.3.4 Төрийн байгууллагуудын нэрийн тэмдгийн дэвсгэр өнгө нь байгууллагын ангиллаас хамааран алтан шар, хөх цэнхэр, мөнгөлөг өнгөтэй байх ба А хавсралтын А.3-р хүснэгт 1,2,3-р зурагт заасан байдлаар хэрэглэнэ.

5.3.5 Олон аж ахуйн нэгж, байгууллага байрлаж буй байшингийн гадна, дотор талд байрлах хаягийн нэгдсэн самбарт хэмжээ заахгүй бөгөөд архитектур талаасаа тухайн байшин, барилга, орчны дизайнтай нийцсэн, загвар, өнгө үзэмжтэй, гадна эсвэл дотор гэрэлтүүлэгтэй, аль нэг байгууллага солигдох, мэдээлэл нь шинэчлэгдэх үед хялбар өөрчилж болох шийдэлтэй байна.

5.3.6 Олон аж ахуйн нэгж, байгууллага байрлаж буй байшингийн гадна талд эсвэл нэгдүгээр давхарт орох хаалганы орчим ханан дээр тэдгээрийн хаяг бүхий мэдээллийн самбарыг байрлуулна.

5.3.7 Хаягийн нэгдсэн мэдээллийн самбарт барилгын давхар бүрийг доороос нь дээш нь дараалуулан бичиж тухайн давхарт байрлах аж ахуйн нэгж байгууллагын нэр, логог бичнэ.

5.3.8 Хаягийн мэдээллийн самбарт давхар бүрийг доороос нь дээш нь дараалуулан бичиж аж ахуйн нэгжийн лого, нэр, хаалганы дугаарыг В хавсралтын В.1, В.2-р зурагт заасны дагуу байршуулна.

5.3.9 Байшингийн дотор талд давхар бүрт ханан дээр аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн самбар байрлана. Самбарт өрөөний дугаарын дарааллаар аж ахуйн нэгжийн нэрийг дээрээс нь доош нь бичих бөгөөд түүнд тухайн нэгжийн лого, нэр, өрөөний дугаар холбоо барих утасны дугаар байна. *(Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага; MNS 5283: 2022)*

3. Судалгааны хэсэг

Өнөөгийн нийгэмд байгууллага, ААН-ийн хаяг нь зөвхөн мэдээ, мэдээллийн хэрэгсэл төдийгүй хэрэглэгчтэй харилцах хэлний нэгэн чухал хэлбэр болон өргөжиж байна. Иймд энэхүү бүлэгт байгууллагын хаягжилтыг хэрэглээний хэл шинжлэлийн үүднээс авч үзэн, түүний бүтэц, гарал үүслийг судлан шинжлэх болно.

2.1 Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагын хаягжилтын байдалд хийсэн судалгаа

Хүснэгт 1. Төрийн байгууллагын хаягжилтын байдалд хийсэн судалгаа

Төрийн байгууллагын хаяг	MNS 5283: 2022
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг жижиг, дунд үйлдвэрийн газар	<p>Төрийн байгууллагын нэрийн самбар нь нэрийн бичвэр, соёмбо, байгууллагын лого, бэлгэ тэмдэг зэргийг агуулна. Байгууллагын бүтэн нэрийн бичвэр нь Монгол хэл, англи хэл, монгол бичгээр бичигдэнэ.</p> <p>5.3.3 Төрийн байгууллагуудыг дараах байдлаар ангилна. А). Төрийн гүйцэтгэх дээд байгууллага, Яам түүний харьяа агентлаг, газар; б). Аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд; с). Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа байгууллага.</p> <p>5.3.4 Төрийн байгууллагуудын нэрийн тэмдгийн дэвсгэр өнгө нь байгууллагын ангиллаас хамааран алтан шар, хөх цэнхэр, мөнгөлөг өнгөтэй байна.</p>
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мал эмнэлгийн ерөнхий газар	
Зээлийн батлан даалтын сан төвийн бүсийн салбар	
Дархан-Уул аймаг дахь худалдан авах ажиллагааны газар	
Дархан-Уул аймаг дахь төрийн аудитын газар	
Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	
Хөдөө аж ахуйн корпораци төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани	
Дархан-Уул аймгийн 27 дугаар цэцэрлэг	
Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	
Дархан-Уул аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	
Дархан-Уул аймгийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	
Дархан-Уул аймаг дахь шүүхийн тамгын газар	
Дархан-Уул аймгийн прокурорын газар	
Дархан-Уул аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	
Дархан-Уул аймгийн 31 дүгээр цэцэрлэг	
Дархан-Уул аймгийн боловсролын газар	
Дархан-Уул аймгийн соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	
Дархан-Уул аймгийн 12 дугаар багийн төв	

Энэхүү хүснэгтээс харахад Дархан-Уул аймаг дахь төрийн байгууллагуудын хаяг MNS 5283:2022 стандартын дагуу бичигдсэн байна. Энэ нь сайн жишиг болж байна гэж дүгнэж байна.

2.2 Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн хаягжилтын байдалд хийсэн судалгаа

Хүснэгт 2. Зөв бичгийн дүрмийн алдаатай бичигдсэн хаяг, зар сурталчилгаа

Алдаатай хаяг, реклам	Зөв бичиглэл	Дүрэм
5-ээс дээш хурдтай орохыг хориглоно.	5-аас дээш хурдтай орохыг хориглоно.	Монгол үгийн I үед “а,у” байвал хойшид “а” дагана.
“Ган бөмбөлөг ундрага” ХХК	“Ган бөмбөлөг ундарга” ххк	Заримдаг гийгүүлэгчийг эгшигжүүлэх үүргээр орсон балархай эгшиг гээгдэхгүй.
Солонгос гоо сайханы бүтээгдэхүүн	Солонгос гоо сайхны бүтээгдэхүүн	Балархай эгшиг үүрэггүй учир гээгдэнэ.
Байгалын гаралтай хүчирхэг цэвэрлэх үйлчилгээтэй.	Байгалийн гаралтай хүчирхэг цэвэрлэх үйлчилгээтэй.	Зөөлний тэмдгийн дараа урт эгшиг “аа, оо, уу, ий” орвол зөөлний тэмдэг “и” болж иа, ио, иу, ий гэж бичигдэнэ.
Сибирын эрүүл мэнд	Сибирийн эрүүл мэнд	Эгшиг зохицох ёс
Компьютер оношлогоо	Компьютер оношилгоо	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг үүсгэх “л” дагаврыг залгахад “л” дагавар эгшгээ өмнөө авна.
Явах эд анги оношлогоо	Явах эд анги оношилгоо	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг үүсгэх “л” дагаврыг залгахад “л” дагавар эгшгээ өмнөө авна.
Угаах бүртээ гурвалсан хамгаалалтыг хүрт	Угаах бүртээ гуравласан хамгаалалтыг хүрт	Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг үүсгэх “л” дагаврыг залгахад “л” дагавар эгшгээ хойноо авна.
Эмэгтэйчүүд эхо	Эмэгтэйчүүд, эхо	Зэрэгцсэн гишүүн хэд хэдэн үг, хоршоо үгээр бүтсэн бөгөөд таслал тавихгүй бол утга бүрхэгдмээр байвал хооронд нь таслал тавина.
Тансаг тамхины бөөний цэг	“Тансаг” тамхины бөөний цэг	Ном зохиол, сонин сэтгүүл, онгоц хөлөг, үйлдвэр нэгдэл, албан байгууллага зэргийн оноосон нэрийг их төлөв хашилтад хийнэ.
Есөн-Эрдэнэ европ гутал	“Есөн-Эрдэнэ” европ гутал	Ном зохиол, сонин сэтгүүл, онгоц хөлөг, үйлдвэр нэгдэл, албан байгууллага зэргийн оноосон нэрийг их төлөв хашилтад хийнэ.
Rainbow хүнс, жимсний дэлгүүр	“Rainbow” хүнс, жимсний дэлгүүр	Ном зохиол, сонин сэтгүүл, онгоц хөлөг, үйлдвэр нэгдэл, албан байгууллага зэргийн оноосон нэрийг их төлөв хашилтад хийнэ.

ТҮВШИН явах эд ангийн оношлогоо засвар	ТҮВШИН явах эд ангийн оношилгоо засвар	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг үүсгэх “л” дагаврыг залгахад “л” дагавар эгшгээ өмнөө авна.
Автын цахилгаан компьютер оношилогоо	Автын цахилгаан компьютер оношилгоо	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг үүсгэх “л” дагаврыг залгахад “л” дагавар эгшгээ өмнөө авна.
Оношлогоо засвар	Оношилгоо засвар	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг үүсгэх “л” дагаврыг залгахад “л” дагавар эгшгээ өмнөө авна.
“Auto 100 service” компьютер оношилогоо	компьютер оношилгоо	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг үүсгэх “л” дагаврыг залгахад “л” дагавар эгшгээ өмнөө авна.
Төмөрийн худалдаа	Төмрийн худалдаа	Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг үүрэггүй бол гээгдэнэ.

Энэхүү хүснэгтээс үзэхэд “үйл үг бүтээх –л дагаврын дүрэм” болон “цэг цэглэлийн дүрэм”-ийн алдаануудыг хамгийн их давтсан байна.

Хүснэгт 3. Хаягжуулалтын стандартыг зөрчсөн хаяг, зар сурталчилгаа

SMART худалдаа үйлчилгээний төв	<p>MNS 5283:2022</p> <p>6.6 Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын хаягийн бичвэрийг кирилл, монгол бичгээр хослуулан бичнэ. Хэрэв хаяг нь монгол, гадаад хэлээр бичигдэх бол гадаад хаягийн хэмжээ монголынхоос хоёр дахин бага байна.</p> <p>17.1.2.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийг кирил болон үндэсний бичгээр хослуулан, эсхүл дангаар нь бичиж хэвших ажлыг зохион байгуулах;</p>
Сонголт online shop	
Maral fashion shop	
Ганнам Korean restaurant & pub	
Elegant хөшиг тюль	
Korea mart	
Удвал market	
Sport shop	
Era fruits	
Jaba fruit	
Coco shop	
Итгэл Phone shop	
Sakura beauty salon	
Nu look beauty	
Mr & mrs salon	
Egg mart	
Zochil pub & restaurant	
Sondor restaurant	
Ayo online shop	
Hi baby Хүүхдийн тоглоом, нярайн дэлгүүр	
Sky salon	
Café Margad	
Friendly supermarket	
Happy shop	
Сангайн кафе	
Rich hotel	
Golden rose restaurant & lounge	
Phone center	<p>MNS 5283:2022</p> <p>6.6 Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын хаягийн бичвэрийг кирилл, монгол бичгээр хослуулан бичнэ. Хэрэв хаяг нь монгол, гадаад хэлээр бичигдэх бол гадаад хаягийн хэмжээ монголынхоос хоёр дахин бага байна.</p> <p>17.1.2.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийг кирил болон үндэсний бичгээр хослуулан, эсхүл дангаар нь бичиж хэвших ажлыг зохион байгуулах;</p>
S-shop	
Сосо хүүхдийн хувцасны дэлгүүр	
Хөшиг плаза	
Suvd's online shop	
Амжилт photo studio	
Dagina cosmetics	
Royal hotel	
Элит цонх констракшн	
Link hotel	
Hi mommy эх хүүхдийн дэлгүүр	
Jasper hotel	
Эгшиг online shop	
Next phone shop	
Darkhan cosmetics	
Luxury хөшигний салон	
Анд auto service	
Цэлмэг phone shop	
Surprise shop	
Цэгц home shop	

Oscar lounge	MNS 5283:2022
Gift shop	6.6 Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын хаягийн бичвэрийг кирилл, монгол бичгээр хослуулан бичнэ. Хэрэв хаяг нь монгол, гадаад хэлээр бичигдэх бол гадаад хаягийн хэмжээ монголынхоос хоёр дахин бага байна.
Om buuz	
Melsa salon	
Цүнх shop	
Содон дизайн	
Orange billiard lounge	
Root Billiard Club- Дархан	
Art billiard	17.1.2.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийг кирил болон үндэсний бичгээр хослуулан, эсхүл дангаар нь бичиж хэвших ажлыг зохион байгуулах;

Үүнээс үзэхэд Дархан-Уул аймаг дахь ААН, байгууллагууд MNS 5283:2022 стандартыг мөрдөхгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь бага насны хүүхдийн эх хэлний боловсролд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна мэдээллийн ойлгомжгүй байдлыг үүсгэж хэрэглэгчдийг төөрөгдүүлж байна. Иймээс стандартыг мөрдөх нь хэрэглэгчдэд ил тод, ойлгомжтой мэдээлэл хүргэхэд тустай юм гэж үзэж байна.

Хүснэгт 4. Найруулга зүйн алдаатай бичигдсэн хаяг, зар сурталчилгаа

Алдаатай хаяг, реклам	Зөв бичиглэл	Дүрэм
Алт авна, хайлна	Алтыг авна, хайлуулна	Үг буруу сонгосон алдаа
Байгаль эхийн анагаах увидас бүхий бүх төрлийн ургамлууд, цайнууд	Байгаль эхийн анагаах увдис бүхий бүх төрлийн ургамал, цай	-журамласан үг - хэл зүйн алдаа (Олон тооны нөхцөлийг буруу ашигласан)
Малчингийн тамга	Малчны тамга	Хэл зүйн алдаа (Тийн ялгалын нөхцөлийг буруу ашигласан)

Үүнээс дүгнэхэд байгууллагын хаяг, зар сурталчилгаанд хэл зүйн алдааг ихээр гаргасан байна. Энэ нь иргэд болон хэвлэлийн газрууд монгол хэлний онолын ойлголт муу байгаатай холбоотой гэж үзэж байна.



График 1. Хувийн хэвшлийн ААН, байгууллагуудын хаягийн судалгааны үр дүн

Энэхүү графикаас харахад хаягжуулалтын стандартыг зөрчсөн хаяг хамгийн их буюу 71% -ийг эзэлж байна. Энэ нь хаягжуулалтын стандартын талаар мэдлэг болон хяналт, шалгалт муу байгаатай холбоотой юм.

1.3 Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн хаягийн гарал үүсэл ба бүтцийн судалгаа

1. ААН, байгууллагуудын хаягийг гарал үүслийнх нь талаас судлан дараах үр дүнг танилцуулж байна. Үүнд:

Грек гаралтай хаяг:

- Содон дизайн-“дизайн”: Уран сэтгэмж, уран зохиомж, санаа бодол, зураг төсөл гэсэн утгатай.

Франц гаралтай хаяг:

- Orange billiard lounge
- Root Billiard Club- Дархан
- Art billiard- “биллиард”: тусгай тавцан дээрх цохиурын тусламжтайгаар нүхэнд цохиж оруулдаг тоглоом.

- Surprise shop- “Surprise”: санаандгүй бэлэг, гэнэтийн учрал, санамсаргүй бэлэг, санамсаргүй тохиолдол, гэнэтийн зүйл гэсэн утгатай.

- Sakura beauty salon

- Mr & Mrs salon

- Sky salon- “салон”: хуучин ахуйн үйлчилгээний суурин дээр байгуулагдсан үсчин ба нүүр арчилгааны газар

- Сантайн кафе- “кафе”: бага хэмжээний ресторан (тавлаг тухтай орчинд хоол ундаагаар үйлчлэх газар)

Латин гаралтай хаяг:

- Амжилт photo studio-“studio”: Латин хэлний “stadium” — хичээл зүтгэл, оролдлого, судалгаа гэсэн утгатай үгнээс гаралтай.

Хятад гаралтай хаяг:

- Om buuz- “buuz”: Хятад хэлний 包子 (bāozi) гэдэг үгнээс гаралтай. Бууз гэдэг нь гурилаар гадарлаж, дотор нь голчлон татсан мах (үхэр, хонь, гахай, зарим үед тахиа), сонгино, амтлагч орц хийгээд жигнэж болгосон хоол юм.

Япон гаралтай хаяг:

- Mr.Punti lounge & karaoke

- Дубай караоке

- Макс караоке- “караоке”: кара- хий хоосон гэсэн утгатай. Дууны үгийг дэлгэцнээс харж хөгжмийн аянд тохируулан дуулэх цэнгээний газар

- Sakura beauty salon- “sakura”: Интоорын цэцэг, японд ургадаг жижиг цагаан цэцэгт ургамал

Англи гаралтай хаяг:

- Сонголт online shop

- Аyo online shop

- Suvd’s online shop

- Эгшиг online shop- “online shop”: online- холбоотой байх гэсэн утгатай. Мөнгөн гүйлгээ хийх, харилцагчаар бүртгүүлэх зэрэг олон ажлыг хялбарчилсан үйлчилгээний хэлбэр

- Zochil pub & restaurant- “pub”: нийтийн гэсэн утгатай. Урин дулаан цагт гадаа байрладаг шар айраг уух газар

- Хөшиг плаза- “плаза”: худалдааны нээлттэй талбай том хэмжээний худалдааны газар

- Oscar lounge-“Oscar”: Тухайн ондоо бүтээгдсэн кино болон уран бүтээлчдэд олгох хамгийн дээд шагнал

- Анд auto service- “service”: үйлчилгээ гэсэн утгатай. Бараа бүтээгдэхүүн үйлчилгээг хүмүүст хүргэх борлуулах үйл ажиллагаа
- Snooker billiard- 15 ширхэг улаан бөмбөлөг, өөр бусад 7 бөмбөлгийг биллиардны ширээн дээр байрлуулж, тодорхой журмын дагуу нүхэнд цохиж оруулах тоглоом
- Friendly supermarket- “Friendly”: найрсаг, нөхөрсөг гэсэн утгатай.
“supermarket”: өдөр тутмын өргөн хэрэглээний бараа таваарыг худалддаг, худалдан авагчид дотор нь чөлөөтэй явж, бараагаа сонгон үйлчлүүлдэг том хэмжээний дэлгүүр
- Maral fashion shop
- Sport shop
- Happy shop
- S-shop
- Цэгц home shop
- Цүнх shop-“shop”: Бараа бүтээгдэхүүн зардаг газар, дэлгүүр

Аж ахуй, албан байгууллагуудын хаягийн гарал үүслийнх нь талаас судалж үзэхэд
 Грек-1 Хятад-1
 Латин-1 Франц-8
 Япон- 4 Англи-15 гаралтай нэрүүд байгаа нь сонирхол татахуйц байна.




График 2. Хаягийн гарал үүслийн судалгааны үр дүн

Судалгаанаас харахад англи гаралтай хаяг 15 буюу 50 хувь, франц гаралтай хаяг 8 буюу 27 хувь, япон гаралтай хаяг 4 буюу 14 хувь, латин, грек, хятад гаралтай хаягууд 3 буюу 9 хувийг эзэлж байна. Байгууллагын хаягжилтад англи гаралтай үгс зонхилон хэрэглэгдэх болсон нь англи хэл дэлхий нийтийн харилцааны гол хэл болж, олон улсын стандарт, хэрэглээний жишигт нийцэх зайлшгүй шаардлага үүссэнтэй холбоотой гэж дүгнэж байна.

2. ААН, байгууллагуудын хаягийг бүтцийн талаас судлан дараах үр дүнг танилцуулж байна. Үүнд:

Нэг үгнээс бүтсэн:

S-shop, Түвшин

Хоёр үгнээс бүтсэн:

Korea mart, Удвал market, Sport shop, Era fruits, Jaba fruit, Coco shop, Egg mart,

Sondor restaurant, Hi baby, Sky salon, Café Margad, Friendly supermarket, Happy shop, Сангайн кафе, Rich hotel, Phone center, Хөшиг плаза, Royal hotel, Link hotel, Jasper hotel, Darkhan cosmetics, Surprise shop, Oscar lounge, Gift shop, Om buuz, Цүнх shop, Содон дизайн, Art billiard

Гурав ба түүнээс дээш үгнээс бүтсэн:

Ган бөмбөлөг ундарга ХХК, Сибирийн эрүүл мэнд, Тансаг тамхины бөөний цэг, Есөн-Эрдэнэ Европ гутал, Rainbow хүнс, жимсний дэлгүүр, Smart худалдаа үйлчилгээний төв, Сонголт online shop, Maral fashion shop, Ганнам Korean restaurant & pub, Elegant хөшиг тюль, Итгэл phone shop, Sakura beauty salon, Nu look beauty, Mr& mrs salon, Zochil pub & restaurant, Аyo online shop, Golden rose restaurant & lounge, Suvd’s online shop, Амжилт photo studio, Элит цонх констракшн, Hi mommy эх хүүхдийн дэлгүүр, Эгшиг online shop, Next phone shop, Luxury хөшигний салон, Анд auto service, Цэлмэг phone shop, Цэгц home shop, Orange billiard lounge, Root billiard club- Дархан




График 3. Хаягийн бүтцийн судалгааны үр дүн

Дархан-Уул аймаг дахь ААН, байгууллагуудын хаягийн зонхилох хувийг 2 үг хоршсон, 3 ба түүнээс дээш үг хоршсон хаягууд эзэлж байна. Дан ганц үгнээс бүтсэн хаяг ховор байгаагийн учир нь “Оноосон нэр нь нэг төрлийн олон юмны дотроос аль нэгийг нь онцлон ялгахын тулд тусгайлан өгсөн нэр учраас утгын багтаамж нь маш явцуу бөгөөд нэгж ухагдахуун илрүүлдэг. Энэ нэгж ухагдахуун нь нэрлэн тэмдэглэж байгаа тодорхой юмтай нь холбож сэтгэсэн цагт л илэрхий мэдэгдэнэ.” гэсэн ухагдахуунтай холбоотой байна.

3. ААН, байгууллагуудын хаягийн бичвэрийг байрлалын хувьд судлан дараах үр дүнг танилцуулж байна.

Хүснэгт 5. Хаягийн бичвэрийг байрлалын хувьд судалсан нь

№	Бүтцийн хувьд	Жишээ
1	Дан монгол нэршил	Ган бөмбөлөг ундарга, Солонгос гоо сайхны бүтээгдэхүүн, Тансаг тамхины бөөний цэг, Түвшин явах эд ангийн оношилгоо засвар, Есөн-Эрдэнэ европ гутал, Өсөх-мишээл, Хааны хүүхдүүд, Эзэн сэтгэлгээ
2	Гадаад+монгол нэршил	Smart худалдаа үйлчилгээний төв, Elegant хөшиг тюль, Coco хүүхдийн хувцасны дэлгүүр, Hi mommy эх хүүхдийн дэлгүүр, Luxury хөшигний салон
3	Монгол+гадаад нэршил	Сонголт online shop, Удвал market, Итгэл phone shop, Хөшиг плаза, Амжилт photo studio, Эгшиг online shop, Анд auto service, Цэлмэг phone shop, Цэгц home shop, Цүнх shop, Содон дизайн
4	Дан гадаад үгээс бүтсэн	Korea mart, Sport shop, Era fruits, Jaba fruit, Coco shop, Sakura beauty salon, Nu look beauty, Mr& mrs salon, Egg mart, Hi baby, Hi mommy, Sky salon, Friendly supermarket, Happy shop, Rich hotel, Golden rose restaurant & pub, Royal hotel, Link hotel, Phone center, Jasper hotel, Next phone shop, Surprise shop, Oscar lounge, Gift shop, Orange billiard lounge, Art billiard

График 4. Хаягийн бичвэрийг байрлалын хувьд судалсан судалгааны үр дүн



Дархан-Уул аймаг дахь ААН, байгууллагуудын хаягийг байрлалын хувьд авч үзэхэд 53 хувь нь дан гадаад үгээс бүтсэн байгааг харахад гадаад үгийн хэрэглээ, харь хэлний нөлөө их байна гэж үзэж байна.

Дээрх хаяг, зар сурталчилгааг дотор нь ялган задалбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6. Хаягийг үйлчилгээний чиглэлээр ангилсан нь

№	Албан байгууллагын төрөл	Асуулгад хариулах хэлбэр	Албан байгууллагын тоо	Монгол бичгээр давхар бичсэн эсэх	Гадаад хэлээр бичсэн эсэх	Зөв бичих дүрмийн алдаатай эсэх	Хаягуулалтын стандартыг баримталсан эсэх	Найруулгын алдаатай эсэх
1	Төрийн байгууллага	Тийм	22	22	22	0	22	0
		Үгүй		0	0	22	0	18
2	Үсчин, гоо сайхны газар	Тийм	10	0	10	0	0	0
		Үгүй		10	0	10	10	10
3	Жимс, хүнсний дэлгүүр	Тийм	11	1	7	3	1	0
		Үгүй		10	4	8	10	11
4	Зочид буудал	Тийм	11	0	8	0	0	0
		Үгүй		11	3	11	11	11
5	Худалдаа, үйлчилгээний засвар	Тийм	27	4	22	4	4	1
		Үгүй		23	5	23	23	26
6	Авто засварын газар	Тийм	9	0	9	6	0	0
		Үгүй		9	0	3	9	9
7	Эмийн сан	Тийм	3	0	0	1	0	1
		Үгүй		3	3	2	3	2
8	Шатахуун түгээх станц	Тийм	2	0	2	2	0	0
		Үгүй		2	0	0	2	2
9	Хэвлэлийн газар	Тийм	3	0	0	1	0	1
		Үгүй		3	3	2	3	2

Нийт	Тийм	98	27	80	17	27	3
	Үгүй		71	18	81	71	95




График 5. Хаягийг монгол бичгээр давхар бичсэн эсэх

Үүнээс харахад төрийн байгууллагын хаяг 22 хувийг буюу хамгийн их хувийг эзэлж байгаа нь тухайн байгууллагын хариуцлага, үнэлэмжийг харуулж байна гэж үзэж байна.




График 6. Хаягийг гадаад хэлээр бичсэн эсэх

Үүнээс харахад худалдаа, үйлчилгээний газрууд хамгийн ихээр гадаад үгийг хэрэглэсэн байгаа нь харагдаж байна. Зөв, буруугүй стандартыг мөрдөөгүй гадаад үгийг хэт хэрэглэх нь хэрэглэгчдийг төөрөгдүүлж байна гэж үзэж байна.




График 7. Хаягжуулалтын стандартыг баримталсан эсэх

Үүнээс үзэхэд төрийн байгууллага бол стандартыг баримталсан сайн жишиг болж байна. Харин хувийн хэвшлийн ААН, байгууллагууд огт хаягжуулалтын стандартыг мөрдөхгүй байгаа нь энэ талаарх ойлголт болон хяналт, шалгалт муу байна гэж үзэж байна.




График 8. Найруулгын алдаатай хаяг байгаа эсэх

Үүнээс үзэхэд худалдаа үйлчилгээний газар, эмийн сан, хэвлэлийн газрууд хэл зүйн болон найруулгын үндсэн зарчмуудыг зөрчин, утга бүрхэг, эмх цэгцгүй байгаа нь нийтлэг алдаа болж байна.

SWOT шинжилгээний үр дүн:

Хүснэгт 7. SWOT шинжилгээний үр дүн

<p>Давуу тал:</p> <p>Төрийн байгууллагуудын хаяг MNS 5283:2022 стандартын дагуу бичигдсэн нь сайн жишиг болж байна.</p> <p>Зарим ААН, байгууллагууд зөв бичгийн дүрмийн дагуу хаяг, зар сурталчилгаагаа боловсруулсан байна.</p> <p>Хаяг, зар сурталчилгаанд байгууллагын үйл ажиллагааны чиглэл, үйлчилгээний онцлог тодорхой туссан тохиолдол цөөнгүй байна.</p> <p>Судалгааны үр дүн нь монгол хэлний хэрэглээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх чухал баримт болж байна.</p>	<p>Сул тал:</p> <p>Хувийн хэвшлийн ААН-үүдийн ихэнх нь стандарт зөрчсөн.</p> <p>Нийт 76 хаягаас:</p> <p>21 нь зөв бичгийн дүрмийн алдаатай</p> <p>4 нь найруулгын алдаатай</p> <p>51 нь MNS 5283:2022 стандартын зөрчилтэй</p> <p>Хувийн байгууллагууд хаягжуулалтын талаарх хуулийн мэдлэггүй, эсвэл хэрэгжүүлэхгүй байгаа нь асуудал дагуулж байна.</p> <p>Зөв бичгийн дүрмийн алдаатай хаяг, зар сурталчилгаа нь хэрэглэгчдэд үл итгэх байдал төрүүлдэг. Найруулга, үг сонголт буруу байх нь байгууллагын мэргэжлийн бус, хариуцлагагүй дүр төрхийг бий болгодог.</p>
<p>Боломж:</p> <p>Төрийн байгууллагуудын сайн жишигийг сургалт, зөвлөмжөөр дамжуулан хувийн хэвшилд түгээх боломжтой.</p> <p>Стандартад нийцсэн хаягжуулалт нь байгууллагын нэр хүнд, хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэх том боломж.</p> <p>Сургалт, семинар зохион байгуулж хувийн хэвшилд хуулийн зохицуулалт, хэлний соёлын талаарх ойлголт нэмэгдүүлэх боломж бий.</p> <p>Монгол хэлний зөв хэрэглээг хэвшүүлэх замаар байгууллага нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч, хэл соёлоо дээдэлдэг жишиг бүтээгч болж чадна. Энэ нь хэрэглэгчдийн хандлагад эерэг нөлөө үзүүлж, байгууллагын урт хугацааны нэр хүндийг өсгөнө.</p>	<p>Эрсдэл:</p> <p>Стандартыг мөрдөөгүй хаяг, сурталчилгаа нь хэрэглэгчийг төөрөгдүүлэх, буруу ойлголт төрүүлэх магадлалтай.</p> <p>Хяналт шалгалтаар торгууль, хариуцлага хүлээх эрсдэлтэй.</p> <p>Хаяг, зар сурталчилгаанд гадаад үгийг хэт хэрэглэх нь олон нийтийн дунд “ингэж бичих нь зөв, хэвийн” гэх ташаа ойлголт бий болгож, хэлний алдааг хэвшил болгох аюултай. Энэ нь цаашлаад ирээдүйн хэлний соёл, бичгийн боловсролд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.</p> <p>Гадаад үг хэт их хэрэглэх нь монгол хэлний дархлааг сулруулж, хүүхэд багачуудын хэлний хэрэглээнд сөргөөр нөлөөлнө.</p>

Дүгнэлт

Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хаяг, зар сурталчилгаанд хэрэглэгдэж буй хэлний хэрэглээний онцлогийг судалж дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1.Зөв бичгийн дүрмийн 21, найруулгын 4, хаягжуулалтын стандарт зөрчсөн 51 тохиолдол илэрсэн бөгөөд эдгээрийн дийлэнх нь хувийн хэвшлийн байгууллагуудад хамаарах зөрчил байв.

2.Төрийн байгууллагын хаяг, зар сурталчилгаа нь стандартын шаардлагад нийцсэн, найруулгын хувьд цэгцтэй, алдаагүй байсан нь зохион байгуулалт ба хяналттай холбоотой гэж дүгнэсэн.

3.Хаяг, зар сурталчилгаанд гадаад үгийг хэт хэрэглэх, хаягжуулалтын хэмжээ, байршил, хэлбэрийн стандартын шаардлагын зөрчлүүд илэрсэн нь хэлний соёл, үндэсний бичгийн дархлаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг харуулж байна.

4.Судалгааг SWOT шинжилгээний аргаар дүгнэж давуу ба сул тал, боломж, аюул заналуудыг тодорхойлон гаргаж, цаашид байгууллагын хэлний хэрэглээг зөв төлөвшүүлэх, хаягжуулалтын стандарт мөрдөлтийг сайжруулах, олон нийтийн хэлний соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогод эерэг нөлөө үзүүлнэ.

5.Судалгааны үр дүнг Дархан-Уул аймаг дахь Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн гишүүнд танилцуулж, судалгаанаас гарсан санал нь тус зөвлөлийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээнд нийцэж байсан бөгөөд стандарт зөрчсөн байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх бидний санал тусгагдсан нь судалгааны практик ач холбогдлыг улам тодотгож байна.

Санал зөвлөмж:

✓ Хувийн хэвшлийн байгууллагуудад хаяг, зар сурталчилгаагаа боловсруулахдаа Монгол Улсын стандарт (MNS 5283:2022)-ыг мөрдөхийг зөвлөмж болгон хүргэх, стандартын шаардлагын талаарх сургалт, зөвлөгөө зохион байгуулах;

✓ Хаяг, зар сурталчилгаанд гадаад үг, хэллэгийг хэтрүүлэн хэрэглэхээс зайлсхийж, кирилл үсгээр бичих, хэрэв гадаад нэр зайлшгүй шаардлагатай бол стандартын дагуу хэмжээг тэнцвэртэй харгалзах шаардлагыг мөрдүүлэх;

✓ Хаяг, зар сурталчилгаанд ашиглагдаж буй хэл найруулгын зөв бичиг, өгүүлбэрийн бүтэц, цэгцтэй найруулгад хяналт тавих, хэл зүйн засвар оруулах мэргэжлийн зөвлөгөөг авах боломжийг бүрдүүлэх;

✓ Хэлний бодлогын байгууллагууд болон орон нутгийн холбогдох төрийн байгууллагууд хамтран стандарт зөрчсөн хаяг, зар сурталчилгаанд хяналт тавих, хэрэгжилтийг үнэлэх тогтолцоог сайжруулах;

✓ Олон нийтийн хэлний боловсролыг дэмжих үүднээс хаягжуулалт, сурталчилгааны хэлний хэрэглээний ач холбогдол, алдаатай хэрэглээний сөрөг нөлөөллийг таниулах контент, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах;

Cameron, D. (2003). *Gender and language ideologies*. In J. Holmes & M. Meyerhoff (Eds.), *The handbook of language and gender*. Blackwell.

Ном зүй

Монгол хэл дээрх ном зохиолууд:

Бадамдорж Д. (2001) Монгол хэлний утга судлал. Улаанбаатар.

Гэрэлмаа Г. (2023) Хэлний хэрэглээг эргэцүүлэхүй. Улаанбаатар.

Гэрэлмаа Г. (2012) Хэрэглээний хэл шинжлэл. Улаанбаатар.

Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага

- (2004) “Дархан хотын нутаг дэвсгэрт байрлуулах гадна реклам, чимэглэл, мэдээллийн байгууламжийн талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам”
- Мөнхжаргал Б.(2020)“Аж ахуйн нэгжийн оноосон нэрийн зарим асуудалд” магистрын ажил.Дархан.
- МУБИС-НХУС. (2022) Орчин цагийн монгол хэл I, II, Улаанбаатар.
- МУБИС-НХУС. (2015) Монгол хэл бичиг-найруулга зүй. Улаанбаатар.
- Нарантуяа Л.(2006) Шинэ үгийн толь. Улаанбаатар.
- Нарантуяа Л. (2020) “Дархан-Уул аймгийн компани, Аж Ахуйн Нэгжийн оноосон нэрд хийсэн хэлзүйн судалгаа” Дархан.
- Нарантуяа Л. (2015) “Дархан” засаг захиргааны нэгжийн нэрийг цэгцлэх асуудалд “Дархан хотын хөгжлийн стратеги” ЭШОПБХурал
- Өнөрбаян Ц. (2004) “Орчин цагийн монгол хэлний үг зүй”. Улаанбаатар.
- Сарантуяа Г. (2021) “Сэтгэл судлалын шинжлэх ухааны судалгааны аргууд”. Улаанбаатар.
- Хэлний бодлогын үндэсний зөвлөл. (2020) “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”. Улаанбаатар.
- Цахим эх сурвалж:
- <https://estandard.gov.mn/website/home.aspx>
- <https://legalinfo.mn/mn/detail/10932>
- <https://nclp.mn/content/149>

Abstract

In today’s society, organizational signage and advertisements serve not only as tools for providing information but also as essential factors reflecting an organization’s reputation, professional standards, and communication with clients. Although Mongolia has established standards related to organizational signage (MNS 5283:2022), the implementation of these standards in rural areas remains relatively weak, with insufficient monitoring and regulation. Darkhan-Uul Province, being a highly populated region with concentrated sectors such as industry, education, and services, still lacks sufficient research on the quality, linguistic accuracy, and standard compliance of organizational signage. Therefore, this study aims to examine the current state of signage among enterprises and organizations operating in Darkhan-Uul Province, identify common errors and inconsistencies, and contribute to improving the implementation of national signage standards.